

МУИС-Хууль зүйн сургуулийн

Эрх зүйн зүйн 4-р курсын оюутан Б. Баялагмаа

Холбоо барих утас:99694749

Цахим хаяг: bayalagma@yahoo.com

**Сэдэв: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө,
түүний эрх зүйн зохицуулалт**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, түүний эрх зүйн зохицуулалт

Товч агуулга.

Оршил

1. Монгол Улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, түүний эрх зүйн зохицуулалт
2. Польш улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт буюу шүүхийн шийдвэр дээр хийсэн дүн шинжилгээ
3. Герман улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт буюу шүүхийн шийдвэр дээр хийсэн дүн шинжилгээ

Дүгнэлт

Ашигласан эх сурвалж

Оршил

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь нийгэм дэх өөрийн алдаатай сэтгэлгээг засаж өөрчлөх боломжийг хувь хүнд олгодог жам ёсны эрхүүдийн нэг билээ. Өөрөөр хэлбэл тус эрх нь ардчилсан нийгмийн үнэт зүйлс болох төрийн байгууллагаас болон бусад эх үүсвэрээс мэдээлэл авах эрхтэй шууд холбогдох бөгөөд энэ нь иргэний үнэнийг мэдэх эрхийг хангаж байдаг. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16-д “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх” эрх чөлөөг хуульчилсан бөгөөд ардчилсан нийгмийн суурь зарчмыг тусгасан байна. Энэхүү үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхдээ ямар хүрээнд хэрхэн эдлэх, ямар тохиолдолд эрх зүйн хариуцлага оногдуулах гэсэн зааг ялгааг гаргах нь тулгамдсан асуудал болоод байна. Учир нь Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг эдэлсэнийхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь оновчтой эсэх нь эргэлзээтэй байна. Өөрөөр хэлбэл, 1-рт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үр дүнд эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл бий болсон эсэхийг хэрхэн зааглан ангилдаг талаар бусад улс орнуудтай харьцуулах, 2-рт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хамрах хүрээг нарийвчлан тодорхойлох талаар бусад улс орнуудтай харьцуулан судлах болон кейс төвт анализын аргыг ашиглан судлах болно.

1. Монгол Улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, түүний эрх зүйн зохицуулалт

Үндсэн хуулийн 16.16-д “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх” эрхийг хүний эрх, эрх чөлөөний гол цөм нь гэж үзэж болох бөгөөд итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.¹ Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19.3-т “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарах ёстой: 1-рт, бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, 2-рт, Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс хязгаарлалтыг зөвхөн хуулийн дагуу хийж болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нэг хэлбэр нь хэвлэн нийтлэх эрх юм. Монгол Улсад хэвлэн нийтлэх эрхтэй холбоотой харилцааг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг

¹ Ханнс-Зайделийн сан болон Эрх зүйн боловсролын академиас гаргасан “Үндсэн хуулийн тайлбар”, УБ, 2009, 98-р тал

баталгаажуулах бөгөөд тус хуулийн 3-р зүйлийн 3.1-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж зааснаас үзвэл иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь бусдын эрх, нэр төрд халдсан тохиолдолд хязгаарлагдаж хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр байна. Монгол Улсын Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2-т “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.” гэж зохицуулсан нь тус зүйлээр Үндсэн хуулийн 16.16-д заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтыг тодорхойлсон байна. Иргэний зүгээс үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ эдэлж байх явцдаа бусдын нэр төрд халдсан тохиолдолд иргэний², эрүүгийн³ хуулийн дагуу хариуцлага оногдуулдаг. Монгол Улсын хэмжээнд 2009 оны байдлаар Эрүүгийн 110-р зүйлээр “Доромжлох”-6, Эрүүгийн хуулийн 111-р зүйлээр “Гүтгэх”-6 хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.⁴ Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй байдаг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.⁵ Эрүүгийн хуулиар оногдуулж буй ял болон гэмт хэргийн шинж чанартай үйлдэл, хор уршиг нь харилцан тэнцвэртэй байх нь зүй ёсны хэрэг юм. Бусдын нэр төрд халдсан гэсэн үндэслэлээр баривчлах ял өгч байгаа нь ялын тэнцвэртэй байдал алдагдаж байгаа бөгөөд хорих ял бус иргэний журмаар гэм хорыг барагдуулах буюу нэр төрийг эргэн сэргээх, нэр төр, алдар хүндэд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор хариуцлага тооцох нь зүйтэй⁶. Доромжлох, болон гүтгэлэгийн гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй бөгөөд Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн эсэхэд нарийн зааг шалгуур байхгүйгээс иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зөрчигдөж байж болзошгүй байна. Иймд бусад улс орнуудад хэрхэн зохицуулсныг судалвал:

2. Польш улс дах “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт, эрх зохицуулалт

Польш Улсын Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл түгээх эрх чөлөөтэй” гэж тодорхойлсон байна.⁷ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл түгээх, хүлээж авах эрхийг 1997 оны Үндсэн хуульд баталгаажуулсан байна. 1993 онд Польш улс нь “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах” Европын конвенцид гарын үсэг зурсан бөгөөд тус Конвенцийн 10 дугаар зүйлд “Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэж заасан байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үзэл бодлоо зөвөөр илэрхийлэх, олон нийтийн хэвлэлээр, хил хязгаарыг үл харгалзан ямар ч хөндлөнгийн мэдээлэл, үзэл санааг хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.⁸ Үндсэн хуулийн

² Иргэний хуулийн 497-р зүйл. “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.”

³ Эрүүгийн хуулийн 110 “Доромжлох”, Эрүүгийн хуулийн 111 –“Гүтгэх” гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

⁴ ХЗҮХ-н Судалгааны тайлангийн эмхэтгэл, 2010-2011/II/, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчны төлөв байдал, тулгамдсан асуудал”, УБ, 2012, 377-р тал

⁵ Нээлттэй нийгэм форумгаас гаргасан 2010.06 сарын Бодлогын асуудал нийтлэлийн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөлд өгөх санал” илтгэлийн 2-р тал

⁶ Мөн тэнд.

⁷ <http://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm> 2013.12.18-нд сайтаас мэдээлэл авав.

⁸ <http://en.poland.gov.pl/Freedom,of,Speech,and,the,Right,to,Choose,1612.html> 2013.12.18-нд сайтаас мэдээлэл авав.

шүүхээс “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хамрах хүрээг” Үндсэн хуулийн зорилгод нийцүүлж тайлбарладаг байна.

Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр⁹: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба эмчийн ёсзүй. Эмчийн ёс зүйн кодын 52.2-т “Эмч нь өөр эмчийн мэргэжлийн үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэхдээ тухайн эмчийг олон нийтийн өмнө гутаахгүй байх үүрэг хүлээнэ.” гэсэн заалт нь Үндсэн хуульд заасан Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчиж байна хэмээн иргэн Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргажээ. Польшийн Үндсэн хуулийн шүүхээс **1-рт**, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд зөвхөн таатай мэдээлэл нийтэд түгээх бус, гэм хоргүй, төвийг сахисан бүхий л санаа бодлын илэрхийлэл хамаарна. **2-рт**, Гэсэн хэдий ч , үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь олон нийтийн болон хувийн амьдралын бусад асуудлыг хамардаг. Олон нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс эмч нь нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй төдийгүй нөгөө эмчийг олон нийтийн өмнө гутаах эрхгүй бөгөөд үүнийгээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийн зөрчил гэж үзэхгүй. Иймд Үндсэн хуулийн шүүхээс иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчөөгүй гэж үзсэн байна. Дээрх тохиолдолд Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь санаа бодлоо илэрхийлэх бүхий л хэлбэрийг хамаардаг хэдий ч *олон нийтийн эрх ашиг, бусдын нэр төр хөндөгдсөн тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болохоор байна.*

3. Герман улс дах “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

Герман Улсын Үндсэн хуулийн 5-р зүйл-д “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй”, 5.1-т Хүн бүр үг хэлэх, аливаа зүйлийг нийтлэх, дүрслэн илэрхийлэх болон бусдад түгээх эрх чөлөөтэй, мөн түүнчлэн мэдээллийн эх сурвалжийг нээлттэй мэдэгдэх эрхтэй.” гэж заасан бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамрах хүрээг дараах шүүхийн шийдвэрээс тодорхойлвол: ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 1953 оны Шмид-Шпигелд холбогдох Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр:¹⁰

1953 оны 11-р сард Штутгарт хотод болсон олон нийтийн хүлээн авалтан дээр гомдол гаргагч буюу дээд шатны шүүгч Герман Улсын хэвлэл нийтлэлийн байгууллагын 95% нь үйлдвэрчний эвлэлтэй таарамж муутай байдаг бөгөөд ажил олгогчийнхоо хяналтанд байдаг тухай шүүмжилсэн. Дээрх мэдээллийг дараа нь үйлдвэрчний эвлэлийн сэтгүүлд нийтлэсэн бөгөөд энэхүү нийтлэлийг эсэргүүцэж, 7 хоног тутмын Де Шпигел сэтгүүл нь “Волгад баригдсан нь” гэсэн гарчигтай нийтлэл доор тус шүүгч нь коммунист талыг баригч гэсэн нийтлэлийг хэвлүүлжээ. Харин шүүгч Шмид нь өдөр тутмын сонинд: Де Шпигел сэтгүүл нь хүн рүү үндэслэлгүй дайрсан агуулгатай нийтлэлээ буцааж татаж авах тухай болон энэхүү сэтгүүл нь ямар нэгэн үндэслэлгүй худлаа зүйл нийтэлдэг тухай мэдээлэл нийтлүүлсэн. Дэ Шпигел сэтгүүл нь шүүгч Шмидийг хэвлэлийн гүтгэлэг хийсэн гэсэн үндэслэлээр Готтинганий шүүхэд хандсан бөгөөд шүүх Дэ Шпигелийн талд шийдвэрлэсэн бөгөөд, дараа нь давж заалдах шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Ийнхүү шүүгч Шмид нь Германы Үндсэн хуулийн 5-р зүйлд заасан Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дээрх хоёр шүүхийн шийдвэр зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргасан байна. **Үндсэн хуулийн шүүхээс** : Үндсэн хуулийн чухал үзэл баримтлал болох Үндсэн хуулийн 5-р зүйлд заасан “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” нь нийтийн үзэл бодол тухайн үйлдэл/эс

⁹ http://www.trybunal.gov.pl/eng/summaries/documents/SK_16_07_GB.pdf , 2008.4.23-ны Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, 2013.12.18-нд сайтаас мэдээлэл авав.

¹⁰ Donald P.Kommers , “The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany”, 2nd edition, January 1997, p369-372

үйлдэхгүйг хүлээн зөвшөөрч байгаа эсэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ач холбогдол, тухайн эрхийг эдлэхээс үүсэх үр дагавар болон нэр төрийг гутаах¹¹ гэмт хэрэгт холбогдуулж эрүүгийн хуулийг хэрэглэх хүрээг бүрэн дүүрэн тал бүрээс нь авч үзээгүй шийдвэр гаргасан байна. Тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ямар тохиолдолд гэмт хэрэг болох тохиолдлыг нарийн судлаагүйн улмаас энэхүү маргаан үүссэн байна. Гэтэл дээрх тохиолдолд гомдол гаргагч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдэлж байсан бөгөөд дараах байдлаар нотлогдож байна. **1-рт, Үг хэлэх эрх чөлөө нь ардчилсан чөлөөт нийгмийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүний баталгаа нь сэтгэлгээний маргаан үүсгэх, үзэл бодлын уралдаан бий болох зэргээр илэрнэ. 2-рт,** Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон Үгээр сөргөлдөх ойлголтод Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь тайван бус байдлаар илэрхийлэхийг зөвшөөрдөг. Үг хэлэх онол хүрээнд: Хүн бүр улс төр, өөрийнхөө хувийн үзэл бодлыг илэрхийлэх эрхтэй. Тайван бус байдлаар хурц ширүүн өнгө аястай, шүүмжлэл нь хоёр талдаа тэнцвэртэй байх ёстой. Гэхдээ үзэл бодлоо илэрхийлж байгаа бүх хэлбэрийг Үндсэн хуулиар хамгаалдаггүй. Харин эрүүл саруул ухаанаар, ёжилсон байдлаар эсхүл хааяа мэдээллийг санамсаргүй байдлаар худал нийтэлсэн тохиолдлуудыг хамгаалдаг. Энэ тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх ёстой.

Дүгнэлт

1/, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь бусад орнуудын хувьд нийгмийн харилцааны өргөн хүрээг хамарсан ойлголт байна. Тухайлбал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ тайван бус хурц, ширүүн өнгө аястай илэрхийлэж болох бөгөөд нь энэ нь олон нийтийн эрх ашигийг зөрчөөгүй байх ёстой байна.

2/, Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн шүүхэд иргэний зүгээс гомдол гаргахдаа шүүхийн шийдвэр үндсэн эрх зөрчсөн гэж хандах эрхгүй тул Эрүүгийн хуулинд заасан Доромжлох, Гүтгэх гэмт хэрэгт шийтгүүлж буй этгээдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдсөн эсэх, эсхүл үнэн зөв, тохирсон хариуцлага оногдуулсан эсэхэд дүгнэлт хийх бололцоогүй байна.

3/ Монгол Улсад Эрүүгийн хуулийн дагуу иргэнд хариуцлага хүлээлгэхэд, тухайн иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн эсэхэд Үндсэн хуулийн шүүх дүгнэлт гаргах боломжгүй тул, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэний улмаас иргэн хохирсон бол иргэний хуулийн дагуу гэм хорыг арилгах зохицуулалтын хэрэглэсэн нь иргэний эрхийг сэргээхэд илүү ач холбогдолтой байна.

Ашигласан эх сурвалж

1. Үндсэн хууль, УБ, 1992
2. Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966
3. Иргэний хууль, УБ, 2002
4. Эрүүгийн хууль, УБ, 2002
5. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, УБ, 1994
6. Ханнс-Зайделийн сан болон Эрх зүйн боловсролын академиас гаргасан “Үндсэн хуулийн тайлбар”, УБ, 2009

¹¹ Герман Улсын Эрүүгийн хуулийн 193-р зүйлд “Шинжлэх ухаан, урлаг эсхүл худалдааны бүтээгдэхүүн, ямар нэгэн зан үйл эсхүл дээд шатны албан тушаалтны шийдвэр, үйлдэлтэй холбоотой шүүмжлэл болон санаа бодлоо хэвлэл мэдээллээр илэрхийлэхдээ тухайн нөхцөл байдлыг доромжилсон байдлаар нийтэд нийтэлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”.

7. ХЗҮХ-н Судалгааны тайлангийн эмхэтгэл, 2010-2011/II/ , “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчны төлөв байдал, тулгамдсан асуудал” , УБ, 2012
8. Нээлттэй нийгэм форумаас гаргасан 2010.06 сарын Бодлогын асуудал нийтлэлийн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөлд өгөх санал” илтгэл
9. <http://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm>
10. <http://en.poland.gov.pl/Freedom,of,Speech,and,the,Right,to,Choose,1612.html>
http://www.trybunal.gov.pl/eng/summaries/documents/SK_16_07_GB.pdf , Польш улсын Үндсэн хуулийн шүүхийн цахим сайт.
11. Donald P.Kommers , “The Constitutional Jurisprudence of the Federal Republic of Germany” , 2nd edition, January 1997,